

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ҮГ

Монгол Улс дахь гадаад орон судлал, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч, мэргэжлийн байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүл нь 45 дахь жилдээ хэвлэгдэж, 114 дэх дугаараа Та бүхэнд өргөн барьж байна.

Манай сэтгүүл уламжлалт цаасан суурьтайгаар хэвлэгдэхээс гадна сүүлийн жилүүдэд тогтмол цахим хувилбараар давхар тархагддаг болсноор хүртээмж, хандалтын үзүүлэлт эрс нэмэгдэж, өгүүллээ ирүүлэх судлаачид болон өргөн олон уншигчдын анхаарал сонирхлыг улам ихээр татдаг болжээ.

“Олон улс судлал” сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүд эрдэм шинжилгээний хүрээнд эрэлт ихтэй байдгийг www.mori.ac.mn, www.mongoliajol.info/index.php/JIS цахим хуудаснаа буй нийт бүтээлийг 2022 онд 60 гаруй мянган уншигч дэлхийн өнцөг булан бүрээс татан авч ашигласан тоон үзүүлэлт бэлхнээ гэрчлэн харуулж буй юм.

2022 онд тус сэтгүүлийн редакцад гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллүүдэд хөндлөн хянан магадалгаа хийснээр энэ удаагийн дугаарт нийт 7 өгүүллийг эрхэм уншигч таны мэлмийд толилуулж байна.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй өгүүллүүд Монгол Улс ба бүс нутгийн хамтын ажиллагаа, Монгол

Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого, Монгол-Японы харилцаа, Монгол-БНСУ-ын харилцаа, Монгол Улсын “Талын зам” санаачилга болон Монгол-Орос-Хятад гурван улсын эдийн засгийн коридор, АНУ-ын гадаад бодлогын асуудал зэргийг хөнджээ. Мөн шинэ бүтээлийн танилцуулга болон судалгааны сонирхолтой шүүмжүүд багтсан болохыг дуулгахдаа таатай байна.

Ерөнхий эрхлэгчийн хувиар энэхүү дугаарт хэвлэгдэж буй нийт бүтээлийн талаар онцолж товчхон өгүүлэхийг хүсэж байна. Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож буй энэ онд академич Ц.Батбаярын “Монгол ба Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон нь: 50 жилийн өндөрлөгөөс нягтлан шинжихүй” хэмээх өгүүлэл тус сэтгүүлд хэвлэгдсэн болохыг онцолж байна. Тэр бээр уг өгүүлэлдээ хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох түүхэн угтвар нөхцөлийг судлан шинжилсэн үр дүнгээ танилцуулсан ажээ. Үүний зэрэгцээ тус хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор О.Батсайханы “Т.Бавуудорж: Олзлогдсон япон цэргүүдийн хумсны толио дээрх ханзаар бичсэн нэр, хаягийн тухай” хэмээх сонирхолтой өгүүлэл нийтлэгдлээ.

Мөн Монгол Улсын гадаад бодлогын асуудалд холбогдох гурван өгүүлэл багтсан нь доктор

Д.Уламбаярын бичсэн “Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого: Хоёр хөршийн судлаачдын дүн шинжилгээ”, БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Монгол судлалын төвийн нарийн бичгийн дарга, доктор Ду.Шивэйн бичсэн “Монгол Улсын “Талын зам” ба “Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор”, Олон улс судлалын хүрээлэнгийн Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын салбарын эрхлэгч, доктор А.Даваасүрэнгийн бичсэн “Монгол Улс, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд: Боломж ба эрсдэл, аюул занал” зэрэг өгүүлэл болно.

Тус хүрээлэнгийн Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Д.Мягмарын “Монгол Улс, БНСУ-ын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааны боломж” өгүүлэлд хоёр улсын хөдөө аж ахуйн салбарын давуу болон сул талуудыг харьцуулан судалж, БНСУ, цаашилбал дэлхийн зах зээлд эрэлт өндөр цөөн хэдэн төрлийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хоёр талын хамтран ажиллах боломжит хувилбаруудыг дэвшүүлжээ.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн нэг болох АНУ-ын гадаад бодлогод гарч буй өөрчлөлтийг хөндсөн “Төв Азид чиглэсэн АНУ-ын бодлого” өгүүллийг тус хүрээлэнгийн Гуравдагч хөрш судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Л.Бямбаханд бичиж, тус улс цэргээ Афганистанаас гаргаснаар ойр орших Төв Азийн бүс нутгийн талаарх бодлогод гарах өөрчлөлтийг судлан дүн шинжилгээ хийжээ.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны яамны

Шинжлэх ухаан, технологийн сан, ОХУ-ын Суурь судалгааны сангийн дэмжлэгээр 2019-2022 онд хэрэгжүүлсэн “Монгол-Оросын харилцаан дахь “Зөөлөн хүч: харьцуулсан дүн шинжилгээ” хамтарсан төслийн хүрээнд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаач А.Нямдолжин, Н.Ариунгуа, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Будда судлалын хүрээлэн болон Доржи Банзаровын нэрэмжит Буриадын Улсын Их Сургуулийн эрдэмтэн судлаач В.А.Родионов, Л.В.Курас, И.Г.Актамов, И.Ц.Доржиева, Э.В.Цыремпилова, А.В.Комбаев нар “Монгол-Оросын харилцаан дахь “Зөөлөн хүч” хамтын нэг сэдэвт бүтээлийг хэвлүүлэн уншигчдын хүртээл болгосныг бид сэтгүүлийн шинэ дугаарын номын танилцуулга буландаа онцолж, уншигч танаа толилуулж байна.

Энэ удаагийн дугаарт өгүүллээ нийтлүүлсэн эрдэмтэн судлаачид, цаг заваа харамгүй зориулан үнэтэй шүүмж өгсөн шинжээчдэдээ Ерөнхий редакторын зүгээс гүн талархал илэрхийлье.

Олон улс судлал” сэтгүүлийн 2023 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүллээ хэвлүүлэх хүсэлтэй эрдэмтэн судлаач Та бүхэн <https://mongoliajol.info/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээж болохын зэрэгцээ сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ mjis@mas.ac.mn цахим шуудангаар ирүүлбэл бид үргэлж талархалтай хүлээн авах болно.

Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч